



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН ТОГТООЛ

2025 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Төрийн эзэмшлийн хувьцааг хөрвүүлэх тухай

Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” 01 дүгээр тогтоол, Цөмийн энергийн комиссын дүрмийн 3.5, 4.1.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:


1.Орано майнинг компаниас “Бадрах Энержи” ХХК-д олгосон хувьцаа эзэмшигчийн зээлийг хувь нийлүүлсэн хөрөнгөд хөрвүүлсний дараагаар Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан нөхцөлийн дагуу Мон-Атом” ХХК-ийн эзэмшиж буй “Бадрах Энержи” ХХК-ийн 34 хувийн энгийн хувьцааг 10 хувийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Бадрах Энержи” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээ, дүрэмд холбогдох өөрчлөлтийг оруулах ажлыг зохион байгуулахыг “Мон-Атом” ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Д.Далайжаргал) нарт даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ДАМДИННЯМ



1725020010